



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2025/002/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn	Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга: Ч.Болд Утас: 7000-7734 Цахим хаяг: boldch@audit.gov.mn
	Санхүү-Нийцлийн аудитын хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
Улаанбаатар хот 2025 он	Аудитын менежер: Д.Отгонбаяр Утас: 325093 Цахим хаяг: otgonbayard@audit.gov.mn
	Ахлах аудитор: М.Ундармаа Утас: 325093 Цахим хаяг: undarmaam@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон улсын стандарт
БНХАУ	Бүгд найрамдах хятад ард улс
ДБ	Дэлхийн банк
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЗБАХ	Техник зохион байгуулалтын арга хэмжээ
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
УБДС	Улаанбаатар дулааны сүлжээ
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХАБ	Хөдөлмөрийн аюулгүй байдал
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЦЭХ	Цахилгаан эрчим хүч



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025.03.14 № 01/249
танай _____-ны № _____-т

БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД
БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ
СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН ЗАХИРАЛ
Х.ГАНЧУЛУУН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ, тодруулгуудыг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрчим хүчний Сайдын 2024 оны А/15 дугаар тушаалаар их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын 132 нэр төрлийн ажилд нийт 6,380.0 сая төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр 98.5 хувиар биелүүлсэн байна.

Тайлант онд хангах, түгээх үйл ажиллагааны зардалд 38,993.6 сая төгрөг төлөвлөснийг 290.1 сая төгрөгөөр буюу 0.7 хувиар хэтрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд нийт 194,010.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 193,406.3 сая төгрөгийг зарцуулж, татварын өмнөх 604.4 сая төгрөг, татварын дараах 297.6 сая төгрөгийн ашигтай ажиллаж, төлөвлөгөөт алдагдлын хэмжээг 3,582.7 сая төгрөгөөр бууруулж ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Эрчим хүчний Сайдын 2024 оны А/15 дугаар тушаал, компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 01 дүгээр тогтоолоор баталсан компанийн тайлант

оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд тусгагдсан 12 үзүүлэлтээс 11 үзүүлэлтийг бүрэн хангаж, 91.7 хувиар биелүүлж ажилласан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3,771,544,164.65	3,176,860,261.16
1.1.2	Дансны авлага	3,068,609,458.11	2,685,992,102.44
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	480,135,839.98	22,298,407.26
1.1.4	Бусад авлага	9,593,308.40	15,591,900.66
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	2,279,352,299.89	2,331,090,605.81
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	51,347,576.75	6,877,669.82
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	9,660,582,647.78	8,238,710,947.15
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	171,249,189,600.37	174,851,486,513.58
1.2.2	Биет бус хөрөнгө	3,959,900,537.93	4,014,784,407.09
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	421,674,406.02	395,302,575.90
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	175,630,764,544.32	179,261,573,496.57
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	185,291,347,192.10	187,500,284,443.72
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	3,098,882,321.11	3,002,552,315.60
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	1,065,000.00	706,249,853.39
2.1.1.4	НДШ - ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүгийн өглөг	180,953,714.56	207,675,288.43
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	424,959,380.84	497,468,542.89
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	432,000.00	
2.1.12	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-д хамаарах өр төлбөр		
2.1.1.12	Урт хугацаат өрийн тайлант үеийн өглөг	5,458,177,706.06	3,448,685,706.06
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	9,164,470,122.57	7,862,631,706.37
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	33,441,823,474.46	36,438,369,744.92
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	5,716,315,368.51	5,695,279,254.75
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		

2.1.2.5			
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	39,158,138,842.97	42,133,648,999.67
2.2	Өр төлбөрийн нийт дүн	48,322,608,965.54	49,996,280,706.04
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	62,531,339,800.00	62,531,339,800.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	72,311,022,635.90	71,986,566,050.58
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	4,784,384,211.03	5,093,428,804.03
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(2,658,008,420.37)	(2,107,330,916.93)
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	136,968,738,226.56	137,504,003,737.68
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	185,291,347,192.10	187,500,284,443.72

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	163,218,494,494.88	191,985,492,615.38
2	Борлуулалтын өртөг	160,880,605,565.18	185,180,628,505.48
3	Нийт ашиг (алдагдал)	2,337,888,929.70	6,804,864,109.90
4	Түрээсийн орлого	31,070,550.91	41,494,164.63
5	Хүүгийн орлого	23,114,473.79	53,889,834.27
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	1,307,713,166.44	1,320,032,539.34
9	Борлуулалт, маркетингийн зардал	4,329,180,141.35	5,865,543,233.48
10	Ерөнхий ба удирдлагын зардал	500,190,448.65	634,729,509.18
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	1,342,692,671.85	903,056,220.77
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	465,050,337.70	(162,089,803.73)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(979,308,569.98)	(50,441,196.42)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(2,986,534,373.29)	604,420,684.56
19	Орлогын татварын зардал	214,344,147.52	306,863,595.83
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(3,200,878,520.81)	297,557,088.73
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(3,200,878,520.81)	297,557,088.73

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	62,531,339,800.00	73,782,460,063.53	4,070,812,537.66	(1,266,063,141.49)	139,118,549,259.70
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				10,991,642.74	10,991,642.74
3	Залруулсан үлдэгдэл	62,531,339,800.00	73,782,460,063.53	4,070,812,537.66	(1,255,071,498.75)	139,129,540,902.44
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(3,200,878,520.81)	(3,200,878,520.81)
5	Бусад дэлгэрэнгүй орлого			713,571,673.37		713,571,673.37
6	Өмчид гарсан өөрчлөлт		326,504,171.56			326,504,171.56
7	Зарласан ногдол ашиг					-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(1,797,941,599.19)		1,797,941,599.19	-
9	2023 оны 12 сарын 31-ны үлдэгдэл	62,531,339,800.00	72,311,022,635.90	4,784,384,211.03	(2,658,008,420.37)	136,968,738,226.56
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(227,036,385.61)	(227,036,385.61)
11	Залруулсан үлдэгдэл	62,531,339,800.00	72,311,022,635.90	4,784,384,211.03	(2,885,044,805.98)	136,741,701,840.95
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				297,557,088.73	297,557,088.73
13	Бусад дэлгэрэнгүй орлого			309,044,593.00		309,044,593.00
14	Өмчид гарсан өөрчлөлт		155,700,215.00			155,700,215.00
15	Зарласан ногдол ашиг					-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(408,156,800.32)		408,156,800.32	-
17	2024 оны 12 сарын 31-ны үлдэгдэл	62,531,339,800.00	71,986,566,050.58	5,093,428,804.03	(2,107,330,916.93)	137,504,003,737.68

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	138,017,633,773.56	158,944,222,869.34
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	136,372,355,957.74	156,091,665,525.91
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	60,611,882.00	96,926,876.50
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого		
	Бусад мөнгөн орлого	1,584,665,933.82	2,755,630,466.93
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	131,123,021,568.52	152,030,200,361.96
	Ажиллагчдад төлсөн	14,908,044,596.85	18,566,634,619.28
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	4,271,371,156.80	5,192,785,378.30
	Бараа материал худалдан авахад төлсөн	102,325,275,484.89	117,938,299,878.07
	Ашиглалтын зардалд төлсөн	673,898,177.24	684,592,765.59
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	763,598,229.97	714,036,043.00
	Хүүгийн төлбөрт төлсөн	917,465,508.95	1,004,000,172.80
	Татварын байгууллагад төлсөн	4,686,649,931.91	4,233,599,055.32
	Даатгалын төлбөрт төлсөн	7,842,842.00	
	Бусад мөнгөн зарлага	2,568,875,639.91	3,696,252,449.60
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	6,894,612,205.04	6,914,022,507.38
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	27,617,293.79	128,324,734.27
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	4,502,820.00	74,434,900.00
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
	Хүлээн авсан хүүгийн орлого	23,114,473.79	53,889,834.27
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	4,699,980,238.41	2,467,971,679.08
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	4,699,980,238.41	2,467,971,679.08
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(4,672,362,944.62)	(2,339,646,944.81)

3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,852,984,843.21	3,323,356,022.50
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	2,852,984,843.21	3,323,356,022.50
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,854,058,549.27	8,492,415,488.56
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	2,854,058,549.27	8,492,415,488.56
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,073,706.06)	(5,169,059,466.06)
	Валютын ханшийн зөрүү		
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	2,221,175,554.36	(594,683,903.49)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,550,368,610.29	3,771,544,164.65
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,771,544,164.65	3,176,860,261.16

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Үзүүлэлт		Хэмжих нэгж	Өмнөх оны мөн үе	2024 он			
					Төлөвлөгөө	Гүйцэтгэл	дүн	хувь
1	2	3	4	5	6	7	8	
1	1.1 Худалдан авсан цахилгаан	сая кВт*ц	612.4	632.6	686.7	74.3	112.1%	
	ДҮТ ТӨХХК-иас	сая кВт*ц	610.3	630.2	683.9	73.6	112.1%	
	Импортоор	сая кВт*ц	2.1	2.4	2.8	0.7	135.3%	
	1.2 Түгээлтийн нийт алдагдал	хувиар	хувь	6.50%	5.80%	5.80%	-0.70%	-11.5%
		биетээр	сая кВт*ц	40	36.6	39.7	-0.3	-0.7%
	ДҮТ ТӨХХК	хувиар	хувь	6.50%	5.70%	5.70%	-0.80%	-12.0%
		биетээр	сая кВт*ц	39.8	36.2	39.2	-0.6	-1.4%
	Импорт	хувиар	хувь	10.30%	16.00%	17.40%	7.10%	169.6%
		биетээр	сая кВт*ц	0.2	0.4	0.5	0.3	229.4%
	1.3 Борлуулсан ЦЭХ	сая кВт*ц	572.4	596	647	74.6	113.0%	

Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК -ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	үүнээс: ДҮТ ТӨХХК	сая кВт*ц	570.5	594	644.7	74.2	113.0%
	Импорт	сая кВт*ц	1.9	2.1	2.3	0.5	124.5%
	Борлуулалтын дундаж үнэ	төг/кВт*ц	237.1	231.5	237.8	0.7	0.3%
2	Нийт орлого	сая төг	165,949.7	171,433.2	194,010.7	28,061.0	116.9%
	Үүнээс: Борлуулалтын орлого	сая төг	135,271.9	137,482.6	153,285.9	18,014.1	113.3%
	Түгээх үйлчилгээний орлого	сая төг	27,495.2	31,139.5	37,804.4	10,309.2	137.5%
	Импортын ЦЭХ-ний орлого	сая төг	451.4	786.3	895.2	443.7	198.3%
	Үйл ажиллагааны бус орлого	сая төг	2,731.2	2,024.8	2,025.2	(706.0)	-25.8%
3	Нийт зардал	сая төг	168,936.2	175,620.3	193,406.3	24,470.1	114.5%
	Үүнээс: ХАЦЭХ-ний өртөг	сая төг	133,611.4	134,387.5	151,762.9	18,151.5	113.6%
	ХАЦЭХ-ний тариф	төг/кВт*ц	218.9	213.3	221.9	3.0	101.4%
	Хангах, түгээх үйл ажиллагааны зардал	сая төг	31,573.6	38,993.6	39,283.7	7,710.0	124.4%
	Импортын эрчим хүчний зардал	сая төг	524.9	716.2	634.3	109.3	120.8%
	Үйл ажиллагааны бус зардал	сая төг	3,226.2	1,523.0	1,725.4	(1,500.9)	-46.5%
	ҮХЭ-ийн зардал	сая төг	7,773.5	7,800.0	9,922.8	2,149.3	127.6%
4	Татвар төлөхийн өмнөх ашиг, алдагдал	сая төг	(2,986.5)	(4,187.1)	604.4	2,382.1	-79.8%
	Үндсэн үйл ажиллагааны ашиг, алдагдал	сая төг	(2,418.0)	(4,758.9)	43.7	2,374.3	-101.8%
	Импортын эрчим хүчний ашиг, алдагдал	сая төг	(73.5)	70.1	260.9	(187.4)	-454.9%
	Үйл ажиллагааны бус ашиг, алдагдал	сая төг	(495.1)	501.7	299.8	794.9	-160.6%
	Орлогын албан татвар	сая төг	214.3	-	306.9	92.5	43.2%
5	Татварын дараах ашиг, алдагдал	сая төг	(3,200.9)	(4,187.1)	297.6	2,903.3	-9.3%
6	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төг	1.0	1.0	1.0	-	97.9%
7	Нийт авлага	сая төг	3,609.7	3,815.0	2,730.8	(878.9)	75.7%
	Үүнээс: Хэрэглэгчээс авах ЦЭХ-ний авлага	сая төг	2,967.9	3,500.0	2,606.6	(361.3)	87.8%
	Шөнийн тариф, өвлийн хүлэмжийн авлага	сая төг	-	315.0	-	-	0.0%
	Урьдчилж төлсөн зардал	сая төг	51.3	-	6.9	(44.5)	-86.6%
	Хувь хүмүүсээс авах авлага	сая төг	2.1	-	9.8	7.7	456.8%
	Хэрэгжээгүй НӨАТ-ын авлага	сая төг	145.4	-	5.8	(139.6)	4.0%
	Хувь тэнцүүлсэн НӨАТ авлага	сая төг	-	-	22.3	-	0.0%
	Харилцагч байгууллага	сая төг	334.7	-	79.4	(255.3)	0.0%
	ААНОАТ-ын авлага	сая төг	106.2	-	-	(106.2)	100.0%
	Бусад авлага	сая төг	1.9	-	-	(1.9)	0.0%
8	Нийт өр төлбөр	сая төг	48,322.6	46,977.2	49,996.3	1,673.6	103.5%
	Урт хугацаат өр төлбөр	сая төг	39,158.1	43,604.7	42,133.6	2,975.5	107.6%

	Богино хугацаат өр төлбөр	сая төг	9,164.5	3,372.5	7,862.6	(1,301.9)	-14.2%
	Үүнээс: НХА-ийн өглөг	сая төг	2,947.7	2,850.0	2,881.6	(66.1)	-2.2%
	ЦЭХ-ний УТТ	сая төг	425.0	285.0	497.5	72.5	17.1%
	Урт хугацаат өрийн тайлант үеийн өглөг	сая төг	5,458.2	-	3,448.7	(2,009.5)	0.0%
	НӨАТ өглөг	сая төг	181.0	-	681.9	501.0	376.8%
	ААНОАТ өглөг	сая төг	-	-	24.3	24.3	0.0%
	Хүүгийн өглөг	сая төг	-	-	207.7	207.7	0.0%
	Бусад өглөг	сая төг	152.7	237.5	121.0	(31.7)	-20.7%
9	Нийт ажиллагсдын тоо	хүн	529.3	553.0	530.5	1.2	0.2%
10	Нийт цалингийн сан	сая төг	15,439.6	20,027.3	19,498.7	4,059.1	126.3%
	Нэг ажилтны дундаж цалин /сарын/	төг	2,430,664.9	3,017,977.1	3,062,936.1	632,271.2	126.0%
11	Цахилгаан тасалдлын дундаж хугацаа Исайди	мин	721.1	707.0	808.7	87.7	112.2%
	Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ	сая төг	4,317.9	6,380.0	5,902.1	1,584.2	0.0%
12	Үүнээс: Хөрөнгө оруулалт	сая төг	980.3	2,802.4	2,699.1	1,718.8	0.0%
	Их засвар	сая төг	510.8	651.0	515.7	4.9	0.0%
	ТЗБАХ	сая төг	2,826.8	2,926.6	2,687.4	(139.4)	0.0%

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 ТӨХК, түүний үйл ажиллагаа

Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх ТӨХК нь тайлант онд түгээх үйл ажиллагааны хувьд “Шугам, тоноглолын шинэчлэлийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлж, түгээх сүлжээний найдвартай ажиллагааг сайжруулах”, хангах үйл ажиллагааны хувьд “Өсөн нэмэгдэж буй хэрэглэгчдэд ухаалаг технологид суурилсан шуурхай, хүртээмжтэй, иж бүрэн үйлчилгээг үзүүлэх” гэсэн хоёр зорилгыг 2024-2030 онд хэрэгжүүлэхээр тодорхойлжээ.

Тус компани нь ашиглалт үйлчилгээний заагаар хойд тал нь Хэнтий аймгийн Дадал сумаас урд тал нь Дорноговь аймгийн Ханги хилийн боомт хүртэл, зүүн тал нь Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумаас, баруун тал нь Дундговь аймгийн Дэлгэрхангай сум хүртэл, нийт 276.6 м2 газар нутаг дахь Нийслэлийн Багануур дүүрэг, Хэнтий, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь аймгуудын төв, суурин газрын нутаг дэвсгэрт байрлах 54.5 мянга гаруй хэрэглэгчдэд дараах чиглэлүүдийн дагуу үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- Цахилгаан түгээх;
- Цахилгаанаар зохицуулалттай хангах;
- БНХАУ-аас цахилгаан импортлох;
- Монгол улсад ашиглахыг зөвшөөрсөн загварын цахилгааны тоолуур, гүйдлийн трансформатор суурилуулах, засварлах;
- 0.4-110 кв-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засварын ажил, түүний туршилт тохируулгын ажил үйлчилгээ.

Тус компани нь дээрх таван тусгай зөвшөөрлийн эрх үүргийн хүрээнд түгээх, хангах үйл ажиллагааны чиглэлээр Диспетчерийн үндэсний төв ХХК-иас 683.9 сая кВт.цаг

цахилгаан эрчим хүчийг худалдан авч, 644.7 сая кВт.цаг цахилгаан эрчим хүчийг хэрэглэгчдэд түгээн борлуулж байна.

Цахилгаан дамжуулах 0.4–110 кВ-ын агаарын шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээний тусгай зөвшөөрлийн эрх үүргийн хэмжээнд 0.4-110 кВ-ын хүчдэлийн 44 дэд станц, 519 трансформаторын дэд өртөө, 4482.8 км цахилгаан дамжуулах агаарын шугам, 170.3 км кабель шугамын ашиглалт, засварын ажлыг хариуцан ажиллаж байна. Цахилгаан импортлох тусгай зөвшөөрлийн эрх үүргийн хүрээнд Дорноговь аймгийн Ханги хилийн боомтоор 2.8 сая.кВт.цаг цахилгаан эрчим хүчийг импортоор худалдан авч байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор баталсан зохион байгуулалтын бүтцийн дагуу 5 салбар, 8 хэлтэс, 4 алба, нийт 529 ажилтантайгаар компанийн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

3.2 ТӨХК-ийн гадаад, дотоод орчин

Тайлант онд Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль,
- Монгол улсын Сангийн сайдын 2024 оны А/52 дугаар тушаалаар баталсан “Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай” журам;
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд болон Сангийн сайдын хамтарсан 2024 оны А/44, А/40 дугаар тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн анхан шатны маягтын загвар” болон “Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны бүртгэлийн маягт хөтлөх аргачлал”;
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/113 дугаар тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, хадгалах, ашиглах, мэдээлэлд хяналт тавих, нууцлал, аюулгүй байдлыг хангах журам” болон “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний мэдээллийн санг бүрдүүлэх, боловсруулах, түгээх, ашиглах, хянах, хадгалах, хамгаалах журам”;
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/199 дүгээр тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журам”.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Эрчим хүчний яамнаас дотоод аудитыг хэрэгжүүлдэг бөгөөд тайлант онд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр дотоод аудит хийгдсэн байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлтэй холбогдолтой хууль, журам, бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3,771,544.2	3,176,860.3	(594,683.9)
Авлага	3,558,338.6	2,723,882.4	(834,456.2)
Урьдчилж төлсөн тооцоо	51,347.6	6,877.7	(44,469.9)
Бараа материал	2,279,352.3	2,331,090.6	51,738.3
Эргэлтийн бус хөрөнгө	175,630,764.5	179,261,573.5	3,630,809.0
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	185,291,347.2	187,500,284.4	2,208,937.3
Богино хугацаат өр төлбөр	9,164,470.1	7,862,631.7	(1,301,838.4)
Урт хугацаат өр төлбөр	39,158,138.8	42,133,649.0	2,975,510.2
Өр төлбөрийн нийт дүн	48,322,609.0	49,996,280.7	1,673,671.7
Эздийн өмчийн дүн	136,968,738.2	137,504,003.7	535,265.5
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	185,291,347.2	187,500,284.4	2,208,937.3

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж төлсөн тооцоо, бараа материал, хөрөнгө, өр төлбөр, эздийн өмч данстуудад өөрчлөлт гарсан байна. Үүнд:

Тайлант онд мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө 3,176.9 сая болж 594.7 сая төгрөгөөр буурсан нь 2023 оны худалдан авалтаас он дамжин хэрэгжиж байгаа 7 ажлын нийт 444.9 сая төгрөгийн худалдан авалт, “Эрчим хүчний төсөл-2”-ын 2023, 2024 оны хуримтлагдсан зээлийн төлбөр 1,504,000.00\$ буюу 5,167.9 сая төгрөгийг төлсөн зэрэг нь нөлөөлжээ. Тайлант онд бэлэн мөнгөний 15.1 сая төгрөгийн, харилцах дансны 3,161.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Авлага өмнөх оноос 834.4 сая төгрөгөөр буурч 2,723.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь цахилгаан эрчим хүчний авлага 382.6 сая төгрөг, татварын авлага 457.8 сая төгрөгөөр буурснаас шалтгаалсан байна. Авлагын үлдэгдэлд хэрэглэгчээс авах ЦЭХ-ний авлага 2,606.5 сая төгрөг, хувь тэнцүүлсэн НӨАТ-ын авлага 22.3 сая төгрөг, харилцагч байгууллагаас авах авлага 79.4 сая төгрөг, бусад авлага 15.6 сая төгрөг тус тус эзэлж байна.

Тайлант онд урьдчилж төлсөн зардал 44.6 сая төгрөгөөр буурч 6.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан нь диспетчерийн үндэсний төвийн үйлчилгээний төлбөрийн илүү төлөлт 31.7 сая төгрөгөөр буурч 5.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй, УБДС ТӨХК-иас дамжуулан алдагдал бууруулах төслийн зээлийн хүүгийн авлага 227.3 мянган төгрөгөөр буурч 337.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, Таван богд солюншс ХХК-нд принтерийн хор цэнэглүүлэх зардалд 1.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнаснаас тус тус шалтгаалжээ.

Бараа материал данс 51.7 сая төгрөгөөр нэмэгдэж 2,331.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан нь Гүйцэтгэх захирлын 2024 оны А/36 дугаартай тушаалын дагуу аюулгүйн нөөцийн бүрдүүлбэр шинэчлэгдэж цахилгааны сэлбэгээс аюулгүйн нөөцөд, аюулгүйн нөөцөөс цахилгааны сэлбэгт шилжүүлж бүртгэсэнтэй холбоотой өөрчлөлт гарсан байна.

Эргэлтийн бус хөрөнгө 179,261.5 сая төгрөг болж 3,630.8 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ-ний ажил, дахин үнэлгээний нэмэгдэл зэргээс нийт 7,330.9 сая төгрөгийн хөрөнгө нэмж бүртгэсэнтэй холбоотой байна. ТӨБЗГ-ын 2024 оны 600 дугаар тогтоолоор 878.7 сая төгрөгийн хөрөнгө акталсан, 98 дугаар тогтоолоор 577.1 сая төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж өртгийг бууруулсан, 820 дугаар тогтоолоор 279.7 сая төгрөгийн нээлттэй дуудлагын худалдаагаар тээврийн хэрэгслийг худалдсан байна.

Богино хугацаат өр төлбөр өмнөх оноос 1,301.8 сая төгрөгөөр буурч 7,862.6 сая төгрөгөөр тайланд тусгагдсан. Үүнд: Нэг худалдан авагчийн өр төлбөр 66.1 сая төгрөг, “Эрчим хүчний төсөл-2”-ын зээлийн өр төлбөр 2,009.5 сая төгрөг, бэлтгэн нийлүүлэгчийн өр төлбөр 30.2 сая төгрөгөөр тус тус буурч, урьдчилж орсон орлого 72.5 сая төгрөг, татварын өр төлбөр 705.1 сая төгрөг, хүүгийн өр төлбөр 26.7 сая төгрөгөөр тус тус өссөн байна. Үүнд:

- Дансны өр төлбөр 96.3 сая төгрөгөөр буурч, 3,002.5 сая төгрөг,
- Татварын өр төлбөр 705.1 сая төгрөгөөр нэмэгдэж, 706.2 сая төгрөгийн,
- Хүүгийн өр төлбөр 26.7 сая төгрөгөөр нэмэгдэж, 207.6 сая төгрөгийн,
- Урт хугацаат өр төлбөр тайлант үеийн өр төлбөр 3,448.6 сая төгрөгийн
- Бусад богино хугацаат өр төлбөр 0.4 сая төгрөгөөр буурч үлдэгдэлгүй;
- Урьдчилж орсон орлого 72.5 сая төгрөгөөр нэмэгдэж, 497.5 сая төгрөгийн өр төлбөртэй байна.

ЦЭХ-ний урьдчилж төлсөн орлогыг салбараар харуулбал:

- Компани 0.45 сая төгрөг;
- Багануур салбар 48.2 сая төгрөг;
- Дорноговь салбар 107.4 сая төгрөг;
- Дундговь салбар 48.1 сая төгрөг;
- Хэнтий салбар 52.6 сая төгрөг;
- Говьсүмбэр салбар 240.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Урт хугацаат өр төлбөр өмнөх оноос 2,975.5 сая төгрөгөөр нэмэгдэж 42,133.6 сая төгрөг болсон нь “Эрчим хүчний төсөл-2” зээл 2,997.6 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Эзэмшигчийн өмчийн дүн 535.2 сая төгрөгөөр нэмэгдэж, 137,504.0 сая төгрөгөөр тайланд тусгасан нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрчим хүчний Сайдын 2024 оны А/15 дугаар тушаал, компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 01 дүгээр тогтоол, Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 481 дүгээр тогтоолоор Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 171,433.2 сая төгрөгөөр, нийт зардлыг 175,620.3 сая төгрөгөөр, 4,187.1 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 6,380.0 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 194,010.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 193,406.3 сая төгрөгийн зардал гарган, 306.9 сая төгрөгийн татвар тайлагнаж, татварын дараах 297.6 сая төгрөгийн ашигтай тайлагнасан байна.

2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөний 12 үзүүлэлтээс 11 үзүүлэлтийг хангаж, 91.7 хувиар биелүүлж ажилласан байна. Үүнд:

- Зорилт 1: Тайлант хугацаанд худалдан авсан цахилгаан эрчим хүчний төлөвлөгөөг 54.1 сая квт.цагаар илүү буюу 108.5 хувиар, хэрэглэгчдэд борлуулах цахилгаан эрчим хүчний төлөвлөгөөг 108.5 хувиар тус тус биелүүлсэн.
- Зорилт 2: Нийт орлогын төлөвлөгөөг 28,061.0 сая төгрөгөөр илүү буюу 116.9 хувиар биелүүлсэн.
- Зорилт 3: Нийт зардал төлөвлөгөөнөөс 24,470.1 сая төгрөгөөр илүү буюу 14.5 хувиар хэтэрсэн. Үүнд: Худалдан авсан ЦЭХ-ний зардал төлөвлөгөөнөөс 17,375.4 сая төгрөг, хангах, түгээх үйл ажиллагааны зардал 290.1 сая төгрөг, үйл ажиллагааны бус зардал 202.3 сая төгрөгөөр тус тус хэтэрч, импортын ЦЭХ-ний зардлыг 81.9 сая төгрөгөөр хэмнэсэн;
- Зорилт 4,5: Татварын өмнөх 604.4 сая төгрөгийн, татварын дараах 297.6 сая төгрөгийн ашигтай ажиллаж, төлөвлөгөөт алдагдлын хэмжээг 3,582.7 сая төгрөгөөр бууруулсан;
- Зорилт 6: Борлуулалтын нэгжид ногдох зардлыг төлөвлөгөөнөөс 0.03 сая төгрөгөөр хэмнэсэн;
- Зорилт 7: Нийт 2,730.8 сая төгрөгийн авлагатай, зорилтоос 1,084.2 сая төгрөгөөр бууруулсан;
- Зорилт 8: Нийт 49,996.3 сая төгрөгийн өр төлбөр, үүнээс урт хугацаат өр төлбөр 42,133.6 сая төгрөг, богино хугацаат өр төлбөр 7,862.6 сая төгрөгийн өр төлбөртэй, зорилтоос 3,019.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Сангийн яамны хуваарийн дагуу Дэлхийн банкны “Эрчим хүч-2” төслийн 2025 онд төлөгдөх (1,008.0 мян. ам доллар) 3,370.5 сая төгрөгийн урт хугацаат зээлийн өр төлбөр, 207.7 сая төгрөгийн хүүгийн төлбөрийг санхүүгийн тайланд богино хугацаат өр төлбөр дансны урт хугацаат өрийн тайлант үеийн өглөг дансанд бүртгэсэн;

- Зорилт 9: Компанийн хэмжээнд нийт 555 орон тоо батлагдсан бөгөөд гүйцэтгэлээр 531 орон тоотой ажиллаж, хэмнэсэн;
- Зорилт 10: Нийт цалингийн сангийн зардалд 20,027.3 сая төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 19,498.7 сая төгрөгийг зарцуулж, 528.6 сая төгрөг хэмнэсэн;
- Зорилт 11: Тайлант хугацаанд нэг хэрэглэгчид ногдож буй тасалдлын үргэлжлэх дундаж хугацаа Исайди 808.7 минут буюу 101.7 минутаар өссөн;
- Зорилт 12: Их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын нийт 132 нэр төрлийн, 6,380.0 сая төгрөгийн ажлыг хийж гүйцэтгэхээр батлагдсанаас нийт 129 нэр төрлийн 5,902.1 сая төгрөгийн ажлыг гүйцэтгэж, гүйцэтгэлд ногдох төлөвлөгөөг 98.5 хувиар биелүүлж ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн нягтлан бодох бүртгэл болон хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг санхүү-нийцлийн аудитын хэлтсийн ахлах аудитор М.Ундармаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Отгонбаяр, хэлтсийн дарга Х.Түвшинбаяр, дэд дарга Ч.Болд нар тус тус хэрэгжүүлсэн.

Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК нь 2024 оны санхүүгийн тайлангаа Нийслэл дэх Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 08/115 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2023 оны орлогын дэлгэрэнгүй тайлан, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 167,267.0 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 2,509.0 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус компани нь сэлбэг хэрэгсэл, урсгал засвар, төлөөлөн удирдан зөвлөлийн зардал, диспетчерийн зардал, зохицуулалт үйлчилгээний хөлс, түрээсийн зардал, зар сурталчилгааны

зардал, газрын төлбөр, бусад татвар хураамж, ажиллагсдын нийгмийн зардал зэргээс нийт 2,591.9 сая төгрөгийг хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 4 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 24 төрлийн 132,359.8 сая төгрөгийн 1147 мэдээллийг Шилэн дансны цахим системд ил тод байршуулсан эсэхийг шалгахад бүрэн байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцлийн асуудлаар нийт 735.0 сая төгрөгийн зөрчил илэрч 27.2 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 364.4 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 343.3 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өглөө.

4.4.2.1 Тайлант онд 27.2 сая төгрөгөөр дүрэмт хувцас худалдан авсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т “Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан 27.2 сая төгрөгийг холбогдох албан тушаалтнаар төлүүлж, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

4.4.2.2 Тайлант онд тус компанийн худалдан авах ажиллагаатай холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Байдлаг дэд станц, Луус дэд станцын хашаа барих ажлын тендерийн худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа анх батлагдсан тоо хэмжээг бууруулсан ч төсөвт өртгийг бууруулалгүй анхны батлагдсан төсөвт өртгөөр буюу 79.0 сая төгрөгөөр худалдан авалт зохион байгуулсан. Мөн тендерийн баримт бичиг боловсруулахдаа ажил гүйцэтгэх тендерийн жишиг баримт бичгийг ашиглаагүй, бараа материал худалдан авах тендерийн жишиг баримт бичгийг ашиглан тендерийг зохион байгуулсан;
- Үнэлгээний хороо тэвштэй авто краны 165.0 сая төгрөгийн тендерийн баримт бичигт ижил төрлийн гэрээний мэдээлэл ирүүлэх тухай заагаагүй, тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулсан тухай үнэлгээний хороо нь хуралдаж

шийдвэрлээгүй, шалгаруулсан компани нь үйл ажиллагааны чиглэл нь тохирохгүй, ижил төрлийн гэрээ гүйцэтгэсэн туршлага байхгүй;

- Эрүүл монгол хөтөлбөртэй давхардуулж үйл ажиллагааны чиглэл тодорхой бус компанийг удаа дараа сонгон шалгаруулж, 121.3 сая төгрөгийн гэрээ байгуулан ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулж, төсвийг үрэлгэн зарцуулсан.

Эдгээр нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т *"Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална"*, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д *"Хариуцлагатай байх"*, 6 дугаар зүйлийн 6.4.1-д *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, 16 дугаар зүйлийн 16.5.5-д *"батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"* гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй, тендерт оролцогчдыг тэгш боломжоор хангаагүй, хяналт хэрэгжүүлээгүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

4.4.2.3 Тайлант онд ерөнхий гэрээгээр цахим дэлгүүрт байршуулсан 343.3 сая төгрөгийн компьютер, мэдээлэл технологийн тоног төхөөрөмж бусад дагалдах хэрэгслийг өөрийн байгууллага дээр худалдан авах ажиллагааг зохион байгуулж худалдан авсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д *"Улс, орон нутгийн төсөв болон захиалагчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө"*, 4 дүгээр зүйлийн 4.1.8-д *"ерөнхий гэрээний арга"* гэж захиалагчийн тодорхой хугацаанд давтамжтай худалдан авдаг, эсхүл байнгын хэрэгцээтэй бараа, үйлчилгээний нэгж дээд үнэ болон бусад нөхцөлийг тогтоосон ерөнхий гэрээг нэг ба түүнээс дээш оролцогчтой байгуулж, цахим дэлгүүрээс бараа, үйлчилгээ худалдан авахыг"; 9 дүгээр зүйлийн 9.1-д *"Хуульд өөрөөр заагаагүй бол худалдан авах ажиллагааг зохион байгуулах, мэдээлэл солилцох, мэдээллийн ил тод байдлыг хангах ажиллагааг цахим системээр гүйцэтгэнэ"*, 38 дугаар зүйлийн 38.1-д *"Ерөнхий гэрээний аргын хоёрдугаар үе шатанд захиалагч худалдан авах бараа, үйлчилгээний тоо хэмжээ, хүргэх газар, хуваарь бүхий захиалгын хуудсыг цахим системд илгээж, үнийн санал дуудаж цахим дэлгүүрээс худалдан авна"* гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ерөнхий гэрээний нөхцөлөөр төсвийн хөрөнгөөр худалдан авах үндсэн хөрөнгө, бараа материалыг цахим дэлгүүрээс худалдан авч байх зөвлөмж өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар нягтлан бодох бүртгэл болон хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой нийт 1,575.4 сая төгрөгийн 8 зөрчил илэрч шалгагдагч байгууллагад танилцуулсан. Завсрын аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг шалгахад 3 зөвлөмжийг хэрэгжүүлж, 5 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул аудитын илрүүлэлтэд оруулж тооцсон.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар 1,535.8 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал болон хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 8 зөрчил илэрснээс 1.7 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 580.4 сая төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 953.6 сая төгрөгийн 4 зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өгснөөс тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	1,743.0	1	1,743.0	100.0
Албан шаардлага	3	580,397.1	3	580,397.1	100.0
Зөвлөмж	4	953,648.3	4	953,648.3	100.0
Нийт дүн	8	1,535,788.4	8	1,535,788.4	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татах асуудал гараагүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,024.9 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 192.1 сая төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, 832.8 сая төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

5.1.1 Байгууллагын спортын арга хэмжээнд тайлант онд 197.3 сая төгрөгийг төлөвлөснөөс 19.4 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулаагүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5.1.2 Тайлант онд шинээр авсан 140.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Ланд круйзер LC78 маркын автомашиныг ашиглах боломжгүй нөхцөл үүссэн боловч даатгалаас болон бусад байдлаар хохирол барагдуулах арга хэмжээ аваагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-т “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна”, 72 дугаар зүйлийн 72.4-т “Тооллогын комисс дараах үүрэгтэй: 3/ агуулахын эмх цэгц, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, анхан шатны бүртгэлийн хөтлөлт, хэмжих хэрэгслийн баталгаажилт, урьдах тооллогоор

¹Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

өгсөн үүргийн биелэлт зэргийг тооллогын явцад шалгаж, дутагдлыг арилгах арга хэмжээ авах; 5/ "эвдэрсэн, гэмтсэн, чанар байдлаа алдсанаас хэрэгцээнд тохирохгүй болсон тухайн үеийн зах зээлийн үнийн жишгээс хэт өндөр үнээр авсан, хэт доогуур үнээр борлуулсан үндсэн хөрөнгө, түүхий эд, бараа материалын үнэ бүхий зүйлийн жагсаалтыг илрүүлж гэм буруутай хүмүүсээр төлүүлэх буюу данснаас хасуулах тухай саналаа тавих" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хохирол барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй зөрчлийг зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5.1.3 Байгууллагад хамаарал бүхий иргэний хувийн компаниас 32.0 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т "Улс, орон нутгийн төсөв болон захиалагчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө", 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", Засгийн газрын 2024 оны "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 02 дугаар тогтоолын хавсралтын 1 дэх заалттай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авалтыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу хийгээгүй, хяналт хэрэгжүүлээгүй зөрчлийг зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой

Илрүүлэлт-1: Сургалтын тайлан, гүйцэтгэл дутуу анхан шатны баримтаар ажил гүйлгээ хийсэн нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар ажил, гүйлгээ бүртгэхгүй байх, салбаруудын удирдлагууд зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах;

Илрүүлэлт-2: Контент хийлгэхээр 20.0 сая төгрөгийн гэрээ байгуулсан боловч гэрээний үүргийн гүйцэтгэлийг гэрээнд заасан хугацаанд хангуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-т "Хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Гэрээний үүргийн гүйцэтгэлийг гэрээнд заасан хугацаанд хангуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх;

2. Бараа материалын данстай холбоотой:

Илрүүлэлт-1: Сэлбэг, аюулгүй байдлын хөрөнгө хадгалах агуулахгүйгээс 790.0 сая төгрөгийн хөрөнгийн хадгалалт хамгаалалт алдагдсан байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-т "Төрийн өмчит хуулийн

этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", 72 дугаар зүйлийн 72.4-т "Тооллогын комисс дараах үүрэгтэй: 3/ агуулахын эмх цэгц, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, анхан шатны бүртгэлийн хөтлөлт, хэмжих хэрэгслийн баталгаажилт, урьдах тооллогоор өгсөн үүргийн биелэлт зэргийг тооллогын явцад шалгаж, дутагдлыг арилгах арга хэмжээ авах" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: *Шаардлагатай арга хэмжээг авч, хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах;*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 30-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчил

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс:			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Дүн	Тоо
Спортын арга хэмжээнд төлөвлөснөөс 19.4 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан.	1	19,400.0	1	19,400.0		
Тайлант онд шинээр авсан Ланд круйзер LC78 маркын автомашиныг ашиглах боломжгүй нөхцөл үүссэн боловч даатгалаас болон бусад байдлаар хохирол барагдуулах арга хэмжээ аваагүй байна. (Говьсүмбэр салбар)	1	140,636.4	1	140,636.4		
Байгууллагын үндсэн ажилтны хувийн компаниас шууд худалдан авалт хийсэн. (Говьсүмбэр салбар)	1	32,014.1	1	32,014.1		
Сургалтын тайлан, гүйцэтгэл дутуу анхан шатны баримтаар ажил гүйлгээ хийсэн. (Дорноговь салбар 19.0 сая төгрөг, Говьсүмбэр салбар 3.0 сая төгрөг)	1	22,000.0			1	22,000.0
Сэлбэг, аюулгүй байдлын хөрөнгө хадгалах агуулахгүйгээс 790.0 сая төгрөгийн хөрөнгийн хадгалалт хамгаалалт алдагдсан. (Төв компани)	1	790,802.4			1	790,802.4
Контент хийлгэхээр гэрээ байгуулсан боловч гэрээний үүргийн гүйцэтгэлийг гэрээнд заасан хугацаанд хангуулаагүй.	1	20,000.0			1	20,000.0
Дүн	6	1,024,852.9	3	192,050.5	3	832,802.4

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Дүн	Тоо
Тайлант онд дүрэмт хувцас худалдан авах ажлыг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж худалдан авсан.	1	27,234.0	1	27,234.0				
Тендерийг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй.	1	364,385.0			1	364,385.0		
Тайлант онд цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй.	1	343,342.5					1	343,342.5

Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК -ийн 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

Дүн	3	734,961.5	1	27,234.0	1	364,385.0	1	343,342.5
------------	----------	------------------	----------	-----------------	----------	------------------	----------	------------------



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 254/АД260246

Улаанбаатар хот

ИТАС-2025/002/УА-СТА-ТӨУГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд тус компанийн худалдан авах ажиллагаатай холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Байдлаг дэд станц, Луус дэд станцын хашаа барих ажлын тендерийн худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа анхны баталсан тоо хэмжээг бууруулсан ч төсөвт өртгийг бууруулалгүй 79,100,000.00 (далан есөн сая нэг зуун мянган) төгрөгөөр худалдан авалт зохион байгуулсан. Мөн тендерийн баримт бичиг боловсруулахдаа ажил гүйцэтгэх тендерийн жишиг баримт бус, бараа материал худалдан авах тендерийн жишиг баримт бичгийг ашиглан тендерийг зохион байгуулсан;
- Үнэлгээний хороо тэвштэй авто краны 165,000,000.00 (нэг зуун жаран таван сая) төгрөгийн тендерийн баримт бичигт ижил төрлийн гэрээний мэдээлэл ирүүлэх тухай заагаагүй, тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулсан тухай үнэлгээний хороо нь хуралдаж шийдвэрлээгүй, шалгаруулсан компани нь үйл ажиллагааны чиглэл нь тохирохгүй, ижил төрлийн гэрээ гүйцэтгэсэн туршлага байхгүй;
- Эрүүл монгол хөтөлбөртэй давхардуулж үйл ажиллагааны чиглэл тодорхой бус компанийг удаа дараа сонгон шалгаруулж, 120,285,000.00 (нэг зуун хорин сая хоёр зуун наян таван мянган) төгрөгийн гэрээ байгуулан ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулж, төсвийг үрэлгэн зарцуулсан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөөлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.9 “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол” заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй, тендерт оролцогчдыг тэгш боломжоор хангаагүй, хяналт хэрэгжүүлээгүй зөрчлийг зогсоож,

1425040053

биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК -ийн захирал Х.Ганчулуун, ерөнхий нягтлан бодогч Т.Болдсанаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР	ХЯНАСАН:	М.УНДАРМАА
САНХҮҮ,НИЙЦЛИЙН АУДИТЫН ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР		Д.ОТГОНБАЯР

¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 257/АД260246

Улаанбаатар хот

ИТАГ-2025/002/НА-СА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагад хамаарал бүхий иргэний хувийн компаниас 32,014,100.00 (гучин хоёр сая арван дөрвөн мянга нэг зуун) төгрөгийн шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т "Улс, орон нутгийн төсөв болон захиалагчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө", 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", Засгийн газрын 2024 оны "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 02 дугаар тогтоолын хавсралтын 1 дэх заалттай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Худалдан авалтыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу хийгээгүй, хяналт хэрэгжүүлээгүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх, биелэлтийг 2025 оны 9 дугаар сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК -ийн захирал Х.Ганчулуун, ерөнхий нягтлан бодогч Т.Болдсанаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР

ХЯНАСАН:

М.УНДАРМАА

САНХҮҮ,НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ОТГОНБАЯР



¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

1405040064



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 256/АД 260276

Улаанбаатар хот

ИТАГ - 2025/002/НА-СА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд шинээр авсан 140,636,363.00 (нэг зуун дөчин сая зургаан зуун гучин зургаан мянга гурван зуун жаран гурван) төгрөгийн төсөвт өртөгтэй Ланд круйзер LC78 маркын автомашиныг ашиглах боломжгүй нөхцөл үүсгэсэн боловч даатгалаас болон бусад байдлаар хохирол барагдуулах арга хэмжээ аваагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", 72 дугаар зүйлийн 72.4-т "Тооллогын комисс дараах үүрэгтэй: 3/ агуулахын эмх цэгц, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, анхан шатны бүртгэлийн хөтлөлт, хэмжих хэрэгслийн баталгаажилт, урьдах тооллогоор өгсөн үүргийн биелэлт зэргийг тооллогын явцад шалгаж, дутагдлыг арилгах арга хэмжээ авах; 5/ "эвдэрсэн, гэмтсэн, чанар байдлаа алдсанаас хэрэгцээнд тохирохгүй болсон тухайн үеийн зах зээлийн үнийн жишгээс хэт өндөр үнээр авсан, хэт доогуур үнээр борлуулсан үндсэн хөрөнгө, түүхий эд, бараа материалын үнэ бүхий зүйлийн жагсаалтыг илрүүлж гэм буруутай хүмүүсээр төлүүлэх буюу данснаас хасуулах тухай саналаа тавих" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Хохирол барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй зөрчлийг зогсоож, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК -ийн захирал Х.Ганчулуун, ерөнхий нягтлан бодогч Т.Болдсанаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР

ХЯНАСАН:

М.УНДАРМАА

САНХҮҮ,НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ОТГОНБАЯР

1. Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

1405040062



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 255/А0260226

Улаанбаатар хот

ИТАГ-2025/002/НА-СТН-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд байгууллагын спортын арга хэмжээнд төлөвлөснөөс 19,400,000.00 (арван есөн сая дөрвөн зуун мянган) төгрөгийг хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулаагүй зөрчлийг зогсоож, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК -ийн захирал Х.Ганчулуун, ерөнхий нягтлан бодогч Т.Болдсанаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР

ХЯНАСАН:

М.УНДАРМАА

САНХҮҮ,НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ОТГОНБАЯР



1. Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

1117145633



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

᠑᠗᠒5 оны ᠐3 дугаар сарын 14

№ 74/А᠐2᠖᠐27᠖

Улаанбаатар хот

НТАГ-᠑᠗᠒5/᠐02/НА-СА-ТӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 27,234,000.00 (хорин долоон сая хоёр зуун гучин дөрвөн мянга) төгрөгөөр дүрэмт хувцас худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т "Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.6-д "эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан" заалтад заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1.Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК зориулалт бусаар зарцуулсан 27,234,000.00 (хорин долоон сая хоёр зуун гучин дөрвөн мянга) төгрөгийг Нийслэл дэх Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь НТАГ.хүү орлогын 100200000908 дугаар дансанд төвлөрүүлэх;

2.Актыг барагдуулж, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн захирал Х.Ганчулуун, ерөнхий нягтлан бодогч Т.Болдсанаа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОНТ:

АХЛАХ АУДИТОР

ХЯНАСАН:

М.УНДАРМАА

САНХҮҮ,НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ОТГОНБАЯР



¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

1425050026